

ДЭМБ-ЫН ТАМХИНЫ  
ХЯНАЛТЫН СУУРЬ  
КОНВЕНЦ

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН  
БАГА ХУРЛЫН  
АЖЛЫН ДҮРЭМ

2018  
ОНЫ ХЭВЛЭЛ



**FCTC**

WHO FRAMEWORK CONVENTION  
ON TOBACCO CONTROL

ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн Оролцогч талуудын Бага хурал. ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн Оролцогч талуудын Бага хурлын ажлын дүрэм

*2018 оны хэвлэлд Оролцогч талуудын Бага хурлын 2018 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн наймдугаар хуралдаанаар баталсан нэмэлт өөрчлөлтүүдийг тусгасан болно.*

ISBN 978-92-4-151214-5

### © Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 2019

Зарим эрхийг хамгаалав. Энэ хэвлэмэл ажил нь Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike3.0 IGO licence (CC BY-NC-SA 3.0 IGO; <https://creativecommons.org/licenses/by-nc-sa/3.0/igo>) лицензийн хүрээнд хийгдсэн болно.

Лицензийн нөхцөлд заасанчлан энэхүү хэвлэмэл ажлыг доорх зааврын дагуу зохих ёсоор иш татаж, худалдааны бус зорилгоор хувилж, түгээж, өөрийн шаардлагад нийцүүлэн өөрчилж болно. Энэ хэвлэмэл ажлыг ямар нэг хэлбэрээр ашиглахдаа тодорхой байгууллага, бараа буюу үйлчилгээг ДЭМБ-аас зөвлөмж болгож байгаа мэтээр ойлгуулахыг хориглоно. ДЭМБ-ын логог ашиглахыг зөвшөөрөхгүй. Хэрэв энэ хэвлэмэл ажлыг өөрийн шаардлагад нийцүүлэн өөрчилсөн бол Та өөрийн ажилдаа ижил буюу Creative Commons байгууллагын өөр төстэй лиценз авах шаардлагатай. Энэ хэвлэмэл ажлыг орчуулсан бол зохих ёсоор иш татахын зэрэгцээ "Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас энэхүү орчуулгыг хийж гүйцэтгээгүй болно. ДЭМБ энэхүү орчуулгын агуулга, үнэн зөв байдлыг хариуцахгүй. Англи эх хувилбар нь тохиролцсон, үнэн зөв хувилбар болно" гэсэн мэдэгдэлтэйгээр хэвлэнэ.

Лицензийн хүрээнд гарсан аливаа маргааныг Дэлхийн оюуны өмчийн байгууллагын маргаан шийдвэрлэх дүрмийн дагуу шийдвэрлэнэ.

**Иш татах заавар.** Conference of the Parties to the WHO Framework Convention on Tobacco Control. Rules of Procedure. Geneva: World Health Organization; 2019. Licence: CC BY-NC-SA 3.0 IGO.

**Хэвлэлийн каталогийн мэдээ.** Хэвлэлийн каталогийн мэдээг <http://apps.who.int/iris> вэбсайтаас харна уу.

**Борлуулалт, эрх, лиценз.** ДЭМБ-ын хэвлэлийг хэрхэн худалдан авах талаар <http://apps.who.int/bookorders> вэбсайтаас харна уу. Худалдааны зорилгоор ашиглах хүсэлт гаргах, эрх болон лицензтэй холбоотой аливаа асуудлаар <http://www.who.int/about/licensing> вэбсайтад хандана уу.

**Гуравдагч этгээдийн материал.** Энэ хэвлэмэл ажилд гуравдагч этгээдээс хуулбарлан авч ашигласан хүснэгт, зураг, дүрслэл зэрэг материалыг ашиглахыг хүсвэл ийнхүү ашиглахад зохиогчийн эрх эзэмшигчээс зөвшөөрөл авах шаардлагатай эсэхийг тодорхойлж, зөвшөөрөл авах нь Таны үүрэг болно. Энэ хэвлэмэл ажилд ашигласан гуравдагч этгээдийн эзэмшдэг аливаа материалын эрхийг зөрчсөнтэй холбоотой маргааныг ийнхүү зөрчсөн этгээд дангаараа бүрэн хариуцна.

**Ерөнхий мэдэгдэл.** Энэхүү хэвлэмэл ажлын агуулга нь аливаа улс, газар, хот, бүс нутгийн эрхзүйн байдал, хил хязгаарын талаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын үзэл баримтлалын илэрхийлэл болохгүй. Газрын зураг дээрх тэмдэглэгээ нь хил хязгаарын ойролцоо илэрхийлэл болно.

Энэхүү хэвлэлд компани, тодорхой үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнийг дурьдсан нь энэхүү бүтээгдэхүүнийг ДЭМБ-аас зөвлөмж болгосон эсхүл бусад ижил төрлийн бүтээгдэхүүнээс илүүд үзсэн гэсэн үг биш. Хэвлэлд алдаа гарсан байхыг үгүйсгэхгүй. Зохиогчийн эрхээр хамгаалагдсан бүтээгдэхүүний нэрийн эхний үсгийг томоор бичсэн болно.

Энэхүү хэвлэлд байгаа мэдээллийг баталгаажуулах боломжтой бүхий л арга хэмжээг ДЭМБ-ын зүгээс авсан болно. Гэхдээ алдаа мадаг байхгүй гэх баталгаа өгөх боломжгүй. Энэхүү хэвлэл дэх мэдээллийг хэрхэн тайлбарлаж, ашиглах нь уншигчийн хариуцлага бөгөөд түүний хэрэглээнээс үүдсэн аливаа хохирлын хариуцлагыг ДЭМБ хүлээхгүй.

*ДЭМБ-ын Хэвлэлийн газарт Швейцар Улсын Женев хотноо хэвлэв.*

## ГАРЧИГ

<b>ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ</b> .....	<b>5</b>
Дүрэм 1 .....	5
<b>НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	<b>5</b>
Дүрэм 2 .....	5
<b>ХУРАЛДААН</b> .....	<b>6</b>
Дүрэм 3 .....	6
Дүрэм 4 .....	6
Дүрэм 5 .....	6
<b>ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ</b> .....	<b>6</b>
Дүрэм 6 .....	6
Дүрэм 7 .....	7
Дүрэм 8 .....	7
Дүрэм 9 .....	7
Дүрэм 10 .....	7
Дүрэм 11 .....	7
Дүрэм 12 .....	7
Дүрэм 13 .....	8
<b>НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ГАЗАР</b> .....	<b>8</b>
Дүрэм 14 .....	8
Дүрэм 15 .....	8
<b>ТӨЛӨӨЛӨГЧИД БА ИТГЭМЖЛЭЛ</b> .....	<b>8</b>
Дүрэм 16 .....	8
Дүрэм 17 .....	8
Дүрэм 18 .....	9
Дүрэм 19 .....	9
Дүрэм 20 .....	9
<b>ХУРАЛ ДАРГАЛАГЧ БА БУСАД СОНГУУЛЬТ АЛБАН ТУШААЛТАН</b> .....	<b>9</b>
Дүрэм 21 .....	9
Дүрэм 22 .....	9
Дүрэм 23 .....	10
Дүрэм 24 .....	10
Дүрэм 24 <sup>1</sup> .....	10
Дүрэм 24 <sup>2</sup> .....	11
Дүрэм 24 <sup>3</sup> .....	11
<b>ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН ХОРОО</b> .....	<b>12</b>
Дүрэм 24 <sup>4</sup> .....	12
<b>ТУСЛАХ БАЙГУУЛЛАГА</b> .....	<b>13</b>
Дүрэм 25 .....	13
Дүрэм 26 .....	13
Дүрэм 27 .....	13
Дүрэм 28 .....	13

<b>АЖИГЛАГЧИД</b> .....	<b>13</b>
Дүрэм 29.....	13
Дүрэм 30.....	14
Дүрэм 31.....	14
<b>ДЭГ</b> .....	<b>14</b>
Дүрэм 32.....	14
Дүрэм 33.....	15
Дүрэм 34.....	15
Дүрэм 35.....	15
Дүрэм 36.....	15
Дүрэм 37.....	15
Дүрэм 38.....	16
Дүрэм 39.....	16
Дүрэм 40.....	16
Дүрэм 41.....	16
Дүрэм 42.....	16
Дүрэм 43.....	16
Дүрэм 44.....	17
Дүрэм 45.....	17
Дүрэм 46.....	17
Дүрэм 47.....	17
Дүрэм 48.....	17
<b>САНАЛ ХУРААЛТ</b> .....	<b>18</b>
Дүрэм 49.....	18
Дүрэм 50.....	18
Дүрэм 51.....	18
Дүрэм 52.....	19
Дүрэм 53.....	19
Дүрэм 54.....	19
Дүрэм 55.....	20
Дүрэм 56.....	20
<b>ХЭЛ БА ТЭМДЭГЛЭЛ</b> .....	<b>20</b>
Дүрэм 57.....	20
Дүрэм 58.....	20
Дүрэм 59.....	20
Дүрэм 60.....	20
Дүрэм 61.....	20
Дүрэм 62.....	20
Дүрэм 63.....	21
Дүрэм 64.....	21
Дүрэм 65.....	21
<b>АЖЛЫН ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ</b> .....	<b>21</b>
Дүрэм 66.....	21
<b>КОНВЕНЦИЙН ХҮЧИН ЧАДАЛ</b> .....	<b>21</b>
Дүрэм 67.....	21

## ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН АЖЛЫН ДҮРЭМ<sup>1</sup>

### ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

#### Дүрэм 1

Оролцогч талуудын Бага хурлын хуралдаан нь энэхүү Ажлын дүрэмд захирагдана. Протоколд тийнхүү заасан, эсхүл протоколд Оролцогч талуудын уулзалтаар тийнхүү шийдвэрлэсэн бол энэхүү ажлын дүрмийг аливаа протоколын Оролцогч талуудын уулзалтад зохих өөрчлөлттэйгөөр (*mutatis mutandis*) мөрдөнө.

### НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

#### Дүрэм 2

Энэ дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1. **“Конвенц”** гэж 2003 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Женев хотноо баталсан ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийг;
2. **“Оролцогч талууд”** гэж Конвенцийн оролцогч талуудыг;
3. **“Оролцогч талуудын Бага хурал”** гэж Конвенцийн 23 дугаар зүйлийн дагуу байгуулсан Оролцогч талуудын Бага хурлыг;
4. **“Хуралдаан”** гэж Конвенцийн 23 дугаар зүйл болон энэхүү дүрмийн дагуу зарлан хуралдуулж буй Оролцогч талуудын Бага хурлын ээлжит буюу ээлжит бус хуралдааныг;
5. **“Бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага”** гэж Конвенцийн 1(b) дүгээр зүйлд тодорхойлсон байгууллагыг;
6. **“Ерөнхийлөгч”** гэж дүрэм 21, түүний 1 дүгээр хэсэгт заасны дагуу сонгогдсон Оролцогч талуудын Бага хурлын Ерөнхийлөгчийг;
7. **“Нарийн бичгийн даргын газар”** гэж Конвенцийн 24 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт заасны дагуу байгуулсан Нарийн бичгийн даргын газрыг;
8. **“Туслах байгууллага”** гэж Конвенцийн 23 дугаар зүйлийн 5(1) хэсэгт нийцүүлэн байгуулсан аливаа бүтцийг;
9. **“Санал хураалтад оролцсон Оролцогч тал”** гэж санал хураалт явуулж буй уулзалтад оролцож, дэмжсэн эсхүл татгалзсан санал өгсөн Оролцогч талыг. Харин санал өгөхөөс түдгэлзсэн Оролцогч талыг санал хураалтад оролцоогүйд тооцно.
10. **“Олон нийтийн хуралдаан буюу уулзалт”** гэж Оролцогч талууд, Конвенцийн оролцогч тал биш улс гүрэн болон бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд, Нарийн бичгийн даргын газар, дүрэм 30 ба 31-ийн дагуу Оролцогч талуудын Бага хурлаас итгэмжлэгдсэн засгийн газар хоорондын ба төрийн бус байгууллагууд, олон нийтийн төлөөлөл оролцоход нээлттэй хуралдаан буюу уулзалтыг;
11. **“Нээлттэй хуралдаан буюу уулзалт”** гэж Оролцогч талууд, Конвенцийн оролцогч тал биш улс гүрэн болон бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд, Нарийн бичгийн даргын газар, дүрэм 30 ба 31-ийн дагуу Оролцогч талуудын Бага хурлаас итгэмжлэгдсэн засгийн газар

<sup>1</sup> ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн Оролцогч талуудын Бага хурлын анхдугаар хуралдаанаар баталж (шийдвэр FCTC/COP1(8)), долоодугаар хуралдаанаар нэмэлт өөрчлөлт оруулсан (шийдвэр FCTC/COP7(28)) бичвэр.

хоорондын ба төрийн бус байгууллагууд оролцоход нээлттэй хуралдаан буюу уулзалтыг;

12. **“Хаалттай хуралдаан буюу уулзалт”** гэж тодорхой зорилгоор болон онцгой нөхцөл байдалд зарлан хуралдуулж, зөвхөн Оролцогч талууд болон Нарийн бичгийн даргын газрын зайлшгүй шаардлагатай ажиллагсад оролцоход нээлттэй хуралдаан буюу уулзалтыг;
13. **“Протокол”** гэж ДЭМБ-ын ТХСК-ийн Оролцогч талуудын бага хурлын 2012 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн тавдугаар хуралдаанаар баталсан Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай Протоколыг;
14. **“Талуудын уулзалт”** гэж Протоколын 33 дугаар зүйлийн дагуу байгуулсан Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай Протоколд оролцогч Талуудын уулзалтыг;

## **ХУРАЛДААН**

### *Дүрэм 3*

Оролцогч талуудын Бага хурлын хуралдааныг Оролцогч талуудын Бага хурлаас өөрөөр шийдвэрлээгүй бол Нарийн бичгийн даргын газрын байрлаж байгаа газарт зарлан хуралдуулна.

### *Дүрэм 4*

1. Оролцогч талуудын Бага хурлаас өөрөөр шийдвэрлээгүй бол Оролцогч талуудын Бага хурлын хоёр ба гуравдугаар ээлжит хуралдааныг жил тутам, дараа дараагийн ээлжит хуралдааныг хоёр жил тутам зарлан хуралдуулна.
2. Ээлжит хуралдаан болгоны үеэр Оролцогч талуудын Бага хурлаас дараагийн ээлжит хуралдааны тов, үргэлжлэх хугацааг тохирно. Хуралдааныг олон тооны төлөөлөгчид оролцоход төвөгтэй үеэр товлохгүй байхыг Оролцогч талуудын Бага хурал эрмэлзэнэ.
3. Оролцогч талуудын Бага хурлын ээлжит хуралдааныг санхүүгийн хоёр жилийн хоёрдугаар хагаст хийхийг эрмэлзэнэ.
4. Оролцогч талуудын Бага хурлын ээлжит бус хуралдааныг хуралдуулах шаардлагатай гэж Бага хурал үзсэн бол, эсхүл хуралдуулах хүсэлтийг аль нэг Оролцогч тал бичгээр гаргаж, түүнийг нь Нарийн бичгийн даргын газраас Оролцогч талуудад мэдэгдсэнээс хойш 6 сарын дотор Оролцогч талуудын гуравны нэгээс багагүй нь дэмжсэн бол зарлан хуралдуулна.
5. Ээлжит бус хуралдааныг Оролцогч талын бичгээр гаргасан хүсэлтийн дагуу зарлан хуралдуулахаар бол Оролцогч талуудын гуравны нэг нь дэмжсэн өдрөөс хойш 90 хоногоос хэтрэхгүй хугацаанд дээрх 3 дахь хэсэгт заасны дагуу хуралдуулна.

### *Дүрэм 5*

Нарийн бичгийн даргын газар нь ээлжит болон ээлжит бус хуралдааны огноо, газрыг хуралдаанаас 60-аас доошгүй хоногийн өмнө бүх Оролцогч талуудад мэдэгдэнэ.

## **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

### *Дүрэм 6*

Нарийн бичгийн даргын газар хуралдаанаар хэлэлцэх асуудлын төслийг Товчоотой зөвлөлдөж гаргана.

### *Дүрэм 7*

Ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлын төсөлд дараах асуудлыг тусгана. Үүнд:

- a) Конвенцийн зүйлүүд, үүнд 23 дугаар зүйлд заасан асуудлууд;
- b) Өмнөх хуралдаанаас хэлэлцэхээр тогтсон асуудлууд;
- c) Дүрэм 13-т заасан асуудлууд;
- d) Төсвийн төсөл болон тайлан тооцоо, санхүүжилттэй холбоотой бүх асуудал;
- e) Оролцогч талуудын Бага хурлаас баталсан арга хэлбэрээр бэлдэж ирүүлсэн Оролцогч талуудын тайлан;
- f) Туслах байгууллагуудын тайлан;
- g) Аль нэг Оролцогч талын санал болгож, Нарийн бичгийн даргын газарт хэлэлцэх асуудлын төслийг тараахаас өмнө ирүүлсэн Конвенцийн хэрэгжилттэй холбоотой аливаа асуудал.

### *Дүрэм 8*

Нарийн бичгийн даргын газар нь ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлын төслийг хурлын бусад бичиг баримтын хамтаар албан ёсны хэл дээр бэлдэж, хуралдааны нээлтээс 6-аас доошгүй хоногийн өмнө Оролцогч талууд болон Дүрэм 29, 30, 31-ийн дагуу хуралдаанд оролцохоор уригдсан ажиглагч нарт хүргүүлнэ.

### *Дүрэм 9*

Ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Оролцогч талуудад хүргүүлсний дараа гэхдээ хуралдааны нээлт хийх өдрөөс 10- аас доошгүй хоногийн өмнө аль нэг Оролцогч талаас ирүүлсэн, ажлын дүрмийн Дүрэм 7-д нийцсэн нэмж хэлэлцэх асуудлын саналыг нарийн бичгийн даргын газар Товчоотой зөвлөлдсөний үндсэн дээр нэмэлт хэлэлцэх асуудлын төсөлд оруулна.

### *Дүрэм 10*

Оролцогч талуудын Бага хурал хэлэлцэх асуудлын төсөл болон нэмэлт хэлэлцэх асуудлын төслийг авч хэлэлцэнэ. Оролцогч талуудын Бага хурал ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлыг батлахдаа асуудал нэмэх, хасах, хойшлуулах, өөрчлөн засварлахаар шийдвэрлэж болно.

### *Дүрэм 11*

Ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлын төсөлд зөвхөн Оролцогч талуудын Бага хурлын ээлжит хуралдаанаас хэлэлцэхээр санал болгосон асуудал эсхүл аль нэг Оролцогч талын ээлжит бус хуралдаан хуралдуулахаар бичгээр гаргасан хүсэлтэд санал болгосон асуудлыг оруулна. Хэлэлцэх асуудлын төслийг ээлжит бус хуралдааны зарын хамтаар Оролцогч талуудад хүргүүлнэ.

### *Дүрэм 12*

1. Нарийн бичгийн даргын газар нь Оролцогч талуудын Бага хурлаар асуудлыг хэлэлцэхийн өмнө тухайн асуудалтай холбоотой гарч болзошгүй захиргааны, санхүүгийн болон төсвийн аливаа үр дагаврын талаар Оролцогч талуудын Бага хуралд танилцуулна.

2. Нарийн бичгийн даргын газраас хэлэлцэх асуудалтай холбоотой гарч болзошгүй захиргааны, санхүүгийн болон төсвийн аливаа үр дагаврын талаар Оролцогч талуудын Бага хуралд 48-аас доошгүй цагийн өмнө танилцуулаагүй бол Оролцогч талуудын Бага хурлаас өөрөөр шийдвэрлэснээс бусад тохиолдолд тухайн асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй.

### *Дүрэм 13*

Ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон боловч хуралдааны үеэр хэлэлцээгүй буюу хэлэлцэж амжаагүй аливаа асуудлыг Оролцогч талуудын Бага хурлаас өөрөөр шийдвэрлээгүй бол дараагийн ээлжит хуралдааны хэлэлцэх асуудлын төсөлд оруулна.

## **НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ГАЗАР**

### *Дүрэм 14*

1. Нарийн бичгийн даргын газрын дарга буюу Нарийн бичгийн даргын газрын даргын төлөөлөгч нь Оролцогч талуудын Бага хурал болон Товчооны бүх хуралдаанд энэ эрх мэдлийнхээ хүрээнд оролцоно.
2. Нарийн бичгийн даргын газрын дарга өөрт байгаа нөөцийн хүрээнд Оролцогч талуудын Бага хурал болон түүний туслах байгууллагуудыг шаардлагатай хүний нөөц, туслах үйлчилгээгээр хангаж, удирдан чиглүүлж, Оролцогч талуудын Бага хурлын Товчоо, түүний туслах байгууллагуудад зохих дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгнө.

### *Дүрэм 15*

Нарийн бичгийн даргын газар нь Конвенц, нэн ялангуяа 24 дүгээр зүйлд заасан чиг үүргээс гадна энэхүү дүрэмд нийцүүлэн дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- a) Хуралдааны үеэр орчуулгын үйлчилгээ зохион байгуулах;
- b) Хуралдааны албан ёсны бичиг баримтыг эмхэтгэх, орчуулах, олшруулах, түгээх;
- c) Хуралдааны албан ёсны бичиг баримтыг хэвлэх, түгээх;
- d) Хуралдааны тэмдэглэл хөтлөх, хадгалах;
- e) Хуралдааны бичиг баримтыг хадгалах, хамгаалах;
- f) Хуралдаан хоорондын Товчооны уулзалтын хэлэлцэх асуудал, баримт бичиг, тэмдэглэлийг бэлдэж, Оролцогч талуудад хугацаанд нь хүргэх;
- g) Оролцогч талуудын Бага хуралд шаардлагатай бусад даалгаврыг гүйцэтгэх.

## **ТӨЛӨӨЛӨГЧИД БА ИТГЭМЖЛЭЛ**

### *Дүрэм 16*

Хуралдаанд оролцож буй Оролцогч тал төлөөлөгчдийн тэргүүн, шаардлагын дагуу итгэмжлэгдсэн тус бүрийг төлөөлөгч, бусад төлөөлөгч, зөвлөхүүдээс бүрдсэн төлөөлөгчид төлөөлнө.

### *Дүрэм 17*

Бусад төлөөлөгч буюу зөвлөх нь төлөөлөгчдийн тэргүүний томилсноор итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлж болно.



### *Дүрэм 18*

Төлөөлөгчийн итгэмжлэл, бусад төлөөлөгч болон зөвлөхүүдийн нэрсийг хуралдааны нээлтээс хойш 24 цагийн дотор Нарийн бичгийн даргын газарт бүрэлдэхүүнд орсон аливаа өөрчлөлтийн талаар Нарийн бичгийн хүлээлгэн өгнө. Төлөөлөгчдийн даргын газарт мэдэгдэнэ. Итгэмжлэлийг төрийн буюу Засгийн газрын тэргүүн, Гадаад харилцааны сайд, Эрүүл мэндийн сайд буюу бусад төрийн эрх бүхий этгээд, бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын хувьд тус байгууллагын эрх бүхий этгээд олгоно.

### *Дүрэм 19*

Товчоо итгэмжлэлийг шалгаж, Оролцогч талуудын Бага хуралд тайлагнана.

### *Дүрэм 20*

Оролцогч талуудын Бага хурлаас итгэмжлэлийг нь хүлээн зөвшөөрөх шийдвэр гаргах хүртэл төлөөлөгчид хуралдаанд оролцох эрхтэй.

## **ХУРАЛ ДАРГАЛАГЧ БА БУСАД СОНГУУЛЬТ АЛБАН ТУШААЛТАН**

### *Дүрэм 21*

1. Оролцогч талуудын Бага хурлын эхний ээлжит хуралдааны үеэр хуралдаанд оролцож буй Оролцогч талуудын төлөөлөгч нараас нэг Ерөнхийлөгч, нэг нь Илтгэгчийн үүрэг гүйцэтгэх таван Дэд ерөнхийлөгчийг сонгоно. Эдгээр сонгуульт албан тушаалтнууд нь Оролцогч талуудын Бага хурлын Товчооны үүрэг гүйцэтгэнэ. ДЭМБ-ын бус тус бүрээс нэг Товчооны гишүүн сонгоно. Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нар Оролцогч талуудын Бага хурлын хоёр дахь ээлжит хуралдаан хаагдтал, түүнчлэн энэ хооронд хуралдах ээлжит бус хуралдаануудын үеэр энэхүү чиг үүргээ хэрэгжүүлнэ.
2. Оролцогч талуудын Бага хуралдааны хоёр дахь болон дараа дараагийн хуралдаан өндөрлөхөөс өмнө дараагийн хуралдааны Товчоонд ажиллах сонгуульт албан тушаалтнуудыг Оролцогч талуудаас сонгоно. Шинээр сонгогдсон сонгуульт албан тушаалтнууд нь хуралдааны хаалтаас эхлэн Оролцогч талуудын Бага хурлын дараагийн ээлжит хуралдааны хаалт хүртэл, түүнчлэн энэ хооронд хуралдах ээлжит бус хуралдаануудын үеэр энэхүү чиг үүргээ хэрэгжүүлнэ.
3. Ерөнхийлөгч, Илтгэгчийг ДЭМБ-ын бүсүүдээс ээлжлэн сонгоно.
  - 3.1. ДЭМБ-ын холбогдох бүсийн Оролцогч талууд өөрөөр шийдвэрлэснээс бусад тохиолдолд аль нэг Оролцогч талыг Товчоонд хоёроос дээш сонгуулийн хугацаанд дараалан сонгохгүй.
4. Ерөнхийлөгч Оролцогч талуудын Бага хурлын хуралдаанд зөвхөн Ерөнхийлөгчийн хувиар оролцох ба нэгэн зэрэг Оролцогч талын төлөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхгүй. Холбогдох Оролцогч тал нь хуралдаанд өөрийг нь төлөөлж, санал хураалтад оролцох эрхийг нь хэрэгжүүлэх өөр төлөөлөгчийг томилно.
5. Туслах байгууллагын даргыг Товчоо тодорхой зорилгоор урьж ажиллуулж болно.

### *Дүрэм 22*

1. Энэ дүрмийн бусад хэсэгт заасны дагуу өөрт нь олгогдсон эрх мэдлийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Ерөнхийлөгч нь хуралдааны нээлт, хаалтыг зарлах, хуралдааныг даргалах, энэхүү Дүрмийн хэрэгжилтийг хангах, үг хэлэх

зөвшөөрөл олгох, санал хураах асуултыг томъёолох, шийдвэрийг танилцуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Тэрээр энэхүү Дүрмийг зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, хуралдааны явцад хяналт тавьж, дэгийг сахиулна.

2. Ерөнхийлөгч Оролцогч талуудын Бага хуралд үг хэлэх төлөөлөгчдийн жагсаалтыг хаах, нэг асуудлаар төлөөлөгч үг хэлэх тоо болон хугацааг тогтоох, хэлэлцүүлгийг түр завсарлуулах буюу хаах, хуралдааныг түр завсарлуулах буюу хаах санал гаргаж болно.
3. Ерөнхийлөгч чиг үүргээ хэрэгжүүлэх явцад Оролцогч талуудын Бага хурлын бүрэн эрхэд захирагдана.

#### *Дүрэм 23*

1. Ерөнхийлөгч хуралдаан буюу түүний тодорхой хэсэгт оролцох боломжгүй бол өөрийг нь орлон Ерөнхийлөгчийн чиг үүргийг хэрэгжүүлэх Дэд ерөнхийлөгчийг томилно. Ийнхүү томилогдсон Дэд ерөнхийлөгч нэгэн зэрэг Оролцогч талын төлөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхгүй.
2. Ерөнхийлөгчийн чиг үүргийг хэрэгжүүлж буй Дэд ерөнхийлөгч Ерөнхийлөгчийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

#### *Дүрэм 24*

1. Товчооны сонгуульт албан тушаалтан хүсэлтээрээ огцорсон эсхүл сонгогдсон хугацаагаа гүйцээх буюу чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүй болсон нөхцөлд сонгуульт хугацааг дуустал түүний оронд Товчоонд ажиллах төлөөлөгчийг тухайн Оролцогч тал дахин томилно. Тухайн Оролцогч тал орны хүнийг санал болгож чадахгүй бол ДЭМБ-ын тухайн бүсээс өөр Оролцогч талын төлөөлөгчийг томилно.
2. Ерөнхийлөгч хуралдаан хоорондын хугацаанд чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй бол аль нэг Дэд ерөнхийлөгч түүнийг орлоно. Дэд ерөнхийлөгчдийн Ерөнхийлөгчийг орлох дарааллыг сонгууль явагдсан хуралдааны үеэр сугалаагаар тогтооно.

#### *Дүрэм 24<sup>1</sup>*

1. Хуралдаан хоорондын Товчооны уулзалтад Оролцогч талуудын Бага хурал буюу Товчооноос өөрөөр шийдвэрлэснээс бусад тохиолдолд Товчооны гишүүд, Нарийн бичгийн даргын газрын зайлшгүй шаардлагатай ажилтнууд оролцоно. Бүсийн зохицуулагч нар Товчооны уулзалтад ажиглагчаар оролцохыг зөвшөөрнө.
2. Товчооны сонгуульт албан тушаалтан болгон Товчооны уулзалтад нэг зэвлэхтэй оролцож болно. Ерөнхийлөгч чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай бол нэмэлт зэвлэхтэй оролцож болно.
3. Товчооны сонгуульт албан тушаалтан Товчооны уулзалтад оролцох боломжгүй бол тухайн Оролцогч тал орлох сонгуульт албан тушаалтныг томилно.
4. Товчооны сонгуульт албан тушаалтан Товчооны уулзалтад хоёр удаа дараалж оролцоогүй бол Нарийн бичгийн даргын газрын дарга энэ тухай Оролцогч талуудын Бага хурлын дараагийн хуралдаанд мэдээлнэ. Оролцогч талуудын Бага хурлаас өөрөөр шийдвэрлээгүй нөхцөлд тухайн Оролцогч тал Товчоонд төлөөлүүлэх эрхээ алдсанд тооцно.
5. Оролцогч талуудын Бага хурлын болон Талуудын Уулзалтын Товчоодын хуралдаан хоорондын хамтарсан уулзалт нь Оролцогч талуудын Бага хурлын болон Талуудын Уулзалтын Товчоодын хамтын шийдвэр

шаардлагатай аливаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор зохион байгуулагдана.

6. Оролцогч талуудын Бага хурлын болон Талуудын Уулзалтын хуралдаан хоорондын Товчооны хамтарсан уулзалт нь Оролцогч талуудын Бага хурлын буюу Талуудын Уулзалтын аль нэг Товчооны хүсэлтийн дагуу, Оролцогч талуудын Бага хурлын буюу Талуудын Уулзалтын Ажлын дүрэмд тусгагдсан бол, мөн аль нэг Товчооноос гаргасан шийдвэрийн дагуу зохион байгуулагдана.

#### *Дүрэм 24<sup>2</sup>*

1. Товчоо нь Оролцогч талуудын Бага хурлаас өгсөн үүрэг Даалгавар болон Дүрэм 6, 9, 19, 21-24-т зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - a. Нарийн бичгийн даргын газрын даргыг томилох талаар ДЭМБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад зөвлөмж өгөх, Талуудын Уулзалтаас өгсөн зааврын дагуу гэрээний хэрэгжилт болон Нарийн бичгийн даргын газрын даргын томилогдсон хугацааг шинэчлэхтэй холбоотой асуудлаар гүйцэтгэлийн үнэлгээ хийх;
  - b. Оролцогч талуудын Бага хурлын туслах байгууллагуудад төлөөлөгч томилох үйл явцад тус дөхөм үзүүлэх;
  - c. Оролцогч талуудын Бага хурлаас баталсан ажлын төлөвлөгөө, төсвийн хэрэгжилтийн талаар Конвенцийн Нарийн бичгийн даргын газрыг удирдамж чиглэлээр хангах;
  - d. Шаардлагатай бол Оролцогч талуудын Бага хуралд танилцуулах тайлан, зөвлөмж, шийдвэрийн төслийг бэлдэхэд нарийн бичгийн даргын газарт удирдамж чиглэл өгөх;
  - e. Оролцогч талуудын Бага хурал болон түүний туслах байгууллагуудын хуралдааныг хуралдуулах огноо, газрыг санал болгох;
  - f. Оролцогч талуудын Бага хуралд ажиглагчаар оролцох хүсэлт гаргасан төрийн бус байгууллагуудын хүсэлтийг үнэлж, үүнтэй холбогдуулан Оролцогч талуудын Бага хуралд зөвлөмж өгөх;
  - g. Оролцогч талуудын Бага хуралд ажиглагчаар оролцох хүсэлт гаргасан олон улсын засгийн газар хоорондын байгууллагуудын хүсэлтийг үнэлж, үүнтэй холбогдуулан Оролцогч талуудын Бага хуралд зөвлөмж өгөх;
  - h. Оролцогч талуудын Бага хурлаас гаргасан хүсэлтийн дагуу бусад асуудлаар Нарийн бичгийн даргын газарт удирдамж чиглэл өгөх.
2. Товчооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Оролцогч талуудад Товчооны үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх зорилгоор Товчооны сонгуульт албан тушаалтнууд холбогдох бүсийн зохицуулагч нартай хамтран Оролцогч талуудын Бага хурлын хуралдааны хооронд тухайн бүсийн Оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоон, зөвлөлдөнө.

#### *Дүрэм 24<sup>3</sup>*

1. Оролцогч талуудын Бага хурлын ээлжит хуралдаанаар дараагийн хуралдааны хаалт хүртэл ажиллах бүсийн зохицуулагчийг ДЭМБ-ын бүс болгоны Оролцогч талууд сонгоно.
2. Бүсийн зохицуулагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - a. Товчооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Оролцогч талуудад Товчооны үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх зорилгоор бүсийг төлөөлж буй Товчооны сонгуульт албан тушаалтантай хамтран ажиллах;

- b. Товчооны ажлын бичиг баримтыг хүлээн авч, бүсийн Оролцогч талуудад хүргүүлсэн эсэхийг баталгаажуулах; Товчооны ажлын бичиг баримттай холбоотой санал авч, Товчооны ажилтанд хүргүүлэх;
  - c. Конвенцийг хэрэгжүүлэх уулзалтуудын зар хүргэх зэргээр мэдээлэл солилцох сувгийн үүрэг гүйцэтгэх, бусад бүсийн зохицуулагч нартай үйл ажиллагааг уялдуулах.
3. Бүсийн зохицуулагч хүсэлтээрээ огцорсон эсхүл сонгогдсон хугацаагаа гүйцээх буюу чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүй болсон нөхцөлд сонгуульт хугацааг дуустал түүний оронд ажиллах төлөөлөгчийг тухайн Оролцогч тал дахин томилно. Тухайн Оролцогч тал орны хүнийг санал болгож чадахгүй бол ДЭМБ-ын тухайн бүсээс өөр Оролцогч талын төлөөлөгчийг томилно.
  4. Бүсийн зохицуулагч хуралдаанд оролцох боломжгүй болсон нөхцөлд түүний орон гүйцэтгэгчийг тухайн Оролцогч тал дахин томилно.

## **ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН ХОРОО**

### *Дүрэм 24<sup>4</sup>*

1. Оролцогч талуудын Бага хурал дараах хороотой байна. Үүнд:
  - a. А хороо буюу гэрээ конвенц, мэргэжлийн асуудлыг хариуцсан хороо;
  - b. Б хороо буюу тайлан, конвенцийн хэрэгжилтэд үзүүлэх дэмжлэг, олон улсын хамтын ажиллагаа, зохион байгуулалтын болон төсвийн асуудлыг хариуцсан хороо.Оролцогч талуудын Бага хурал энэ хоёр хорооноос гадна шаардлагатай бусад хороог байгуулж болно.
2. Хуралдаанд оролцогч талууд хороо тус бүрт нэг буюу түүнээс олон төлөөлөгч, зөвлөх оролцуулах эрхтэй.
3. Хуралдаан болгоны эхэнд нэгдсэн хуралдаанаар Товчооны зөвлөмжид үндэслэн хэлэлцэх асуудлуудыг сэдэвчилсэн бүлгүүдэд ангилж, ажлын ачааллыг тэнцвэржүүлэхүйц байдлаар хоёр хороонд хуваарилна. Цаашид Товчоо хорооны даргын зөвлөмжид үндэслэн шаардлагын дагуу зохицуулалт хийж болно.
4. Хороо тус бүр нэг Дарга, хоёр Дэд даргыг ДЭМБ-ын бүх бүсийн төлөөллийг хангахуйцаар сонгоно. Энэхүү боломжийг ханган нэр дэвшүүлэх үйл ажиллагааг Товчоо удирдан зохион байгуулна.
5. Нэгдсэн хуралдаантай холбоотой Оролцогч талуудын Бага хурлын Ерөнхийлөгчийн хэрэгжүүлдэгтэй ижил чиг үүрэг, хариуцлагыг Хорооны дарга хорооны хурлын үеэр хэрэгжүүлнэ.
6. Хороо хурлыг нээлттэй эсхүл хаалттай хуралдуулахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд хорооны хурал олон нийтийн байна. Энэхүү дүрмийг Конвенцийн 5.3 дугаар зүйлд нийцүүлэн хэрэгжүүлнэ.
7. Оролцогч талуудын Бага хурлаас өөрөөр шийдвэрлээгүй бол хорооны хурлын зохион байгуулалт, санал хураалтад нэгдсэн хуралдааны зохион байгуулалт, санал хураалтын дүрмийг зохих өөрчлөлттэйгөөр (*mutatis mutandis*) мөрдөнө.
8. Хороо тус бүр шаардлагатай гэж үзвэл баримт бичгийн төсөл боловсруулах ажлын хэсгүүдийг байгуулж болно. Төсөл боловсруулах ажлын хэсгийн ахлагч нь ажлын явцыг шуурхайлахын тулд хорооны үйл ажиллагаанд хамааралтай дүрмүүдийг ажлын хэсгийн үйл ажиллагаанд нэгэн адил мөрдөж болно.

## **ТУСЛАХ БАЙГУУЛЛАГА**

### *Дүрэм 25*

1. Конвенцийн 23.5(f) дугаар зүйлд заасанчлан Оролцогч талуудын Бага хурлаас Конвенцийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай туслах байгууллагуудыг байгуулж болно.
2. Оролцогч талуудын Бага хурлаас туслах байгууллага тус бүрийн авч хэлэлцэх асуудал, түүний мандат, зорилт, үйл ажиллагаа явуулах хугацаа, төсвийг тодорхойлж, туслах байгууллагын даргын хүсэлтээр ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулах эрхийг Ерөнхийлөгчид олгож болно.
3. Дүрэм 26-28 зааснаас бусад нөхцөлд туслах байгууллагын үйл ажиллагаанд энэхүү дүрмийг зохих өөрчлөлттэйгөөр (*mutatis mutandis*) мөрдөх ба өөрчлөлтийн агуулгыг Оролцогч талуудын Бага хурлаас шийдвэрлэнэ.

### *Дүрэм 26*

Туслах байгууллага нь хаалттай бол Оролцогч талуудын Бага хурлаас томилсон Оролцогч талуудын энгийн олонх оролцсоныг ирц бүрдсэн гэж үзнэ. Харин туслах байгууллага нь нээлттэй бол Оролцогч талуудын дөрөвний нэг оролцсоныг ирц бүрдсэнд тооцно.

### *Дүрэм 27*

1. Оролцогч талуудын Бага хурлын хуралдаантай нэгэн зэрэг хуралдуулах шаардлагатай эсэхийг харгалзан туслах байгууллагын хуралдааны тов, газрыг Оролцогч талуудын Бага хурлаас тогтооно.
2. Оролцогч талуудын Бага хурал буюу тухайн туслах байгууллага өөрөөр шийдвэрлэснээс бусад тохиолдолд туслах байгууллагын хуралдаан буюу уулзалт нь олон нийтийн байна. Энэхүү дүрмийг Конвенцийн 5.3 дугаар зүйлд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

### *Дүрэм 28*

1. Оролцогч талуудын Бага хурлаас өөрөөр шийдвэрлээгүй бол туслах байгууллагын даргыг тухайн туслах байгууллага сонгоно. Туслах байгууллага тус бүр газар нутгийн ижил тэгш төлөөлөл, хөгжиж буй болон хөгжингүй улс орнуудын ижил тэгш төлөөлөл, хүйсийн тэгш байдлын зарчмыг харгалзан өөрийн сонгуульт албан тушаалтнуудыг сонгоно. Сонгуульт албан тушаалтнууд хоёроос дээшгүй удаа дараалж сонгогдож болно.
2. Туслах байгууллагын дарга эсхүл хуралдааныг даргалж буй дэд дарга өөрийн улсын цор ганц төлөөлөгч биш л бол санал хураалтад оролцохгүй. Хэрэв санал хураалтад оролцохоор бол Дүрэм 49.1-д заасны дагуу санал хураалтад оролцох эрхээ хэрэгжүүлнэ.

## **АЖИГЛАГЧИД**

### *Дүрэм 29*

1. Конвенцийн Оролцогч тал биш ДЭМБ-ын гишүүн улс, ДЭМБ-ын сурвалжлагч гишүүн, Конвенцийн Оролцогч тал биш боловч НҮБ, эсхүл түүний төрөлжсөн байгууллага, эсхүл Олон улсын атомын энергийн агентлагийн гишүүн улс, Конвенцийн Оролцогч тал биш боловч Конвенцийн 1(b) дүгээр зүйлийн тодорхойлолтод нийцсэн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны

байгууллага нь Оролцогч талуудын Бага хурал болон туслах байгууллагуудын олон нийтийн буюу нээлттэй хуралдаан, уулзалтад ажиглагчаар оролцож болно.

2. Ажиглагч нь Оролцогч талуудын Бага хурал болон туслах байгууллагуудын олон нийтийн буюу нээлттэй хуралдаан, уулзалтад санал өгөх эрхгүйгээр оролцох ба зөвхөн Оролцогч талуудын дараа санал хэлэх эрхтэй байна. Бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд зөвхөн өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар санал хэлэх эрхтэй байна.

### *Дүрэм 30*

1. Олон улсын засгийн газар хоорондын аливаа байгууллага өөрийн дотоод журамд нийцүүлэн ажиглагчаар оролцох хүсэлтийг Нарийн бичгийн даргын газарт гаргаж болно. Оролцогч талуудын Бага хурал хүсэлттэй холбоотой Нарийн бичгийн даргын газрын тайлан, Конвенцийн Удиртгалын 17, 18 дугаар хэсэг, 5.3 дугаар зүйлийг харгалзан ажиглагчаар оролцох хүсэлтийг хангаж болно. Тухайн байгууллагын удирдлагын зүгээс зохих ёсоор баталгаажуулсан хүсэлтийг Нарийн бичгийн даргын газарт хуралдааны нээлтээс 90- ээс доошгүй хоногийн өмнө хүргүүлсэн байна.
2. Энэхүү дүрэмд хамаарах ажиглагч нь Дүрэм 29-д заасны нэгэн адил Оролцогч талуудын Бага хурал болон туслах байгууллагуудын олон нийтийн буюу нээлттэй хуралдаан, уулзалтад санал өгөх эрхгүйгээр оролцох ба зөвхөн Оролцогч талуудын дараа санал хэлэх эрхтэй байна.

### *Дүрэм 31*

1. ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн талаар хэлэлцээ хийх засгийн газар хоорондын байгууллага болон ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн засгийн газар хоорондын нээлттэй ажлын хэсгийн үйл ажиллагаанд оролцож байсан төрийн бус байгууллагууд Оролцогч талуудын Бага хурлын ажиглагчийн статустай байна.
2. Конвенцийн үзэл санаа, зорилго, зарчимд нийцсэн зорилго, үйл ажиллагаа бүхий бусад олон улсын болон бүсийн төрийн бус байгууллагууд ажиглагчаар оролцох хүсэлтийг Нарийн бичгийн даргын газарт гаргаж болно. Оролцогч талуудын Бага хурал хүсэлттэй холбоотой Нарийн бичгийн даргын газрын тайлан, Конвенцийн Удиртгалын 17, 18 дугаар хэсэг, 5.3 дугаар зүйлийг харгалзан ажиглагчаар оролцох хүсэлтийг хангаж болно. Хүсэлтийг нарийн бичгийн даргын газарт хуралдааны нээлтээс 90-ээс доошгүй хоногийн өмнө хүргүүлсэн байна.
3. Оролцогч талуудын Бага хурал ээлжит хуралдааны үеэр төрийн бус байгууллага болгоны итгэмжлэлийг үнэлж, ажиглагч хэвээр үлдээх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.
4. Энэхүү дүрэмд хамаарах ажиглагч нь Оролцогч талуудын Бага хурал болон туслах байгууллагуудын олон нийтийн буюу нээлттэй хуралдаан, уулзалтад санал өгөх эрхгүйгээр оролцох ба Дүрэм 29, 30-д заасан ажиглагч нарын дараа санал хэлэх эрхтэй байна.

## **ДЭГ**

### *Дүрэм 32*

Оролцогч талуудын Бага хурал өөрөөр шийдвэрлэснээс бусад тохиолдолд Оролцогч талуудын Бага хурлын хуралдаан нь олон нийтийн байна. Энэхүү дүрмийг Конвенцийн 5.3 дугаар зүйлд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

### *Дүрэм 33*

Оролцогч талууд шинэ санал, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг Нарийн бичгийн даргын газарт албан ёсны аль нэг хэлээр, бичгээр гаргаж өгнө. Нарийн бичгийн даргын газар саналыг төлөөлөгчдөд хүргүүлнэ. Хуралдаан эхлэхээс 3 хоногийн дотор Оролцогч талуудад хүргүүлсэн шинэ санал, нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг авч хэлэлцэхгүй. Гэхдээ Оролцогч талуудын Бага хурлаас зөвшөөрсөн нөхцөлд Оролцогч талуудад хүргүүлээгүй буюу тухайн өдөр нь хүргүүлсэн шинэ санал, нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг хэлэлцэж болно.

### *Дүрэм 34*

1. Оролцогч талуудын энгийн олонх оролцож байгаа нөхцөлд Оролцогч талуудын Бага хурлын нэгдсэн хуралдааныг хуралдуулах ирц бүрдсэнд тооцно. Аливаа шийдвэрийг батлахын тулд Оролцогч талуудын гуравны хоёроос доошгүй нь оролцсон байх шаардлагатай.
2. Бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын эрх мэдэлд хамаарах асуудлаар шийдвэр гаргах ирц бүрдсэн эсэхийг тодорхойлохдоо Конвенцийн 32.2 дугаар зүйлд заасны дагуу тухайн байгууллага хэдэн санал өгөх эрхтэйг харгалзан тухайн байгууллагыг тооллогод хамруулна.

### *Дүрэм 35*

1. Ерөнхийлөгчөөс урьдчилж зөвшөөрөл авахгүйгээр нэг ч төлөөлөгч хуралдаанд хандаж үг хэлж болохгүй. Дүрэм 36, 38, 42-д заасанчлан Ерөнхийлөгч үг хэлэх хүсэлт гаргасан дарааллынх нь дагуу төлөөлөгчдөд үг хэлэх эрх олгоно. Нарийн бичгийн даргын газар үг хэлэх төлөөлөгчдийн жагсаалтыг гаргана. Төлөөлөгчийн үг нь хэлэлцэж буй асуудалд хамааралгүй байвал Ерөнхийлөгч сануулга өгч, дэгийг сахиулж болно.
2. Хэлэлцүүлгийн явцад Ерөнхийлөгч үг хэлэх төлөөлөгчдийн жагсаалтыг зарлаж, Бага хурлын зөвшөөрснөөр жагсаалтыг хаасныг зарлаж болно. Жагсаалтыг хаасны дараа хэлсэн Үгтэй холбоотой хариу өгөх шаардлагатай гэж үзвэл Ерөнхийлөгч төлөөлөгчид хариу хэлэх эрх олгож болно.
3. Ерөнхийлөгч буюу аль болгосноор Оролцогч талуудын Бага хурлаас үг хэлэх нэг Оролцогч талын санал хугацаа болон нэг асуудлаар нэг төлөөлөгч хэдэн удаа үг хэлэх тал дээр хязгаар тогтоож болно. Ийнхүү хязгаар тогтоох талаар шийдвэр гаргахын өмнө саналыг дэмжиж буй хоёр, эсэргүүцэж буй хоёр төлөөлөгчид үг хэлэх боломж олгоно. Хязгаар тогтоосон нөхцөлд төлөөлөгч зөвшөөрсөн хугацааг хэтрүүлсэн бол Ерөнхийлөгч тэр даруй сануулга өгч, дэгийг сахиулна.

### *Дүрэм 36*

1. Туслах байгууллагын дүгнэлтийг тайлбарлах зорилгоор туслах байгууллагын дарга буюу илтгэгчид хэлэлцүүлгийг чиглүүлэх эрх олгож болно.
2. Нарийн бичгийн даргын газрын дарга эсхүл түүний томилсноор Нарийн бичгийн даргын газрын өөр гишүүн Ерөнхийлөгчийн зөвшөөрснөөр хэлэлцэж буй асуудалтай холбоотой нэмэлт мэдээлэл, тодруулга, тайлбар өгөх зорилгоор амаар буюу бичгээр үг хэлж болно.

### *Дүрэм 37*

Ерөнхийлөгч хүсэлт гаргасан аль нэг төлөөлөгчид хариу хэлэх эрх олгож болно. Төлөөлөгч энэхүү эрхээ хэрэгжүүлэхдээ уулзалтын төсгөлд аль болох товч үг хэлэхийг эрмэлзэнэ.

### *Дүрэм 38*

Аливаа асуудлыг хэлэлцэх явцад аль нэг төлөөлөгч дэг сахиулах хүсэлт гаргаж болох ба Ерөнхийлөгч тэрхүү хүсэлтийн дагуу энэхүү Дүрэмд нийцүүлэн шийдвэр гаргана. Аль нэг төлөөлөгч Ерөнхийлөгчийн шийдвэрийг эсэргүүцэж болно. Эсэргүүцлийг тэр даруй санал хураалтаар шийдвэрлэж, санал хураалтад оролцсон Оролцогч талуудын энгийн олонх нь Ерөнхийлөгчийн шийдвэрийг хүчингүй болгосноос бусад тохиолдолд шийдвэр хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Дэг сахиулах хүсэлт гаргасан төлөөлөгч хэлэлцэж буй асуудалтай холбоотой санал хэлж болохгүй.

### *Дүрэм 39*

1. Аливаа асуудлыг хэлэлцэх явцад аль нэг төлөөлөгч хуралдааныг түр завсарлуулах буюу хойшлуулах санал гаргаж болно. Саналыг хэлэлцэхгүй, харин тэр даруй санал хураалт явуулна.
2. Энэхүү Дүрэмд "хуралдааныг түр завсарлуулах" гэж хуралдаан дунд түр зуур амсхийхийг, "хуралдааныг хойшлуулах" гэж хуралдааны үйл ажиллагааг дараагийн хуралдаан зарлан хуралдуулах хүртэл зогсоохыг ойлгоно.

### *Дүрэм 40*

Аливаа асуудлыг хэлэлцэх явцад аль нэг төлөөлөгч тухайн асуудлын хэлэлцүүлгийг хойшлуулах санал гаргаж болно. Санал гаргасан төлөөлөгчөөс гадна саналыг дэмжиж хоёр, эсэргүүцэж хоёр төлөөлөгч тус тус үг хэлж болно. Ийнхүү үг хэлсний дараа санал хураалт явуулна.

### *Дүрэм 41*

Аль нэг төлөөлөгч дангаар эсхүл бусад төлөөлөгчидтэй хамтран хэлэлцүүлгийг хаасны дараа тухайн асуудлаар үг хэлэх зөвшөөрөл олгохыг хүсч болно. Зөвшөөрлийг хоёроос илүүгүй төлөөлөгчид олгож болох ба үүнээс хойш асуудлыг санал хураалтаар шийдвэрлэнэ. Оролцогч талуудын Бага хурал хэлэлцүүлгийг хаахаар шийдвэрлэсэн нөхцөлд Ерөнхийлөгч хэлэлцүүлгийг хаасныг мэдэгдэнэ. Улмаар Оролцогч талуудын Бага хурал хэлэлцүүлгийг хаахаас өмнө дэвшүүлсэн саналууд дээр санал хураалт явуулна.

### *Дүрэм 42*

Дэгийг сахиулахаас бусад хүсэлтийн дарааллыг дараах байдлаар тогтооно.

Үүнд:

- a) Хуралдааныг түр завсарлуулах;
- b) Хуралдааныг хойшлуулах;
- c) Тухайн асуудлаар хэлэлцүүлгийг хойшлуулах;
- d) Тухайн асуудлаар хэлэлцүүлгийг хаах.

### *Дүрэм 43*

Оролцогч талуудын Бага хурал тухайн асуудлыг хэлэлцэх, төслийн санал буюу төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах чадамжтай эсэхийг шийдвэрлэх хүсэлт гаргасан тохиолдолд хэлэлцэж буй асуудлаар санал хураалт явуулахаас өмнө хүсэлтийг Дүрэм 42- ыг харгалзан санал хураалтаар шийдвэрлэнэ.



#### *Дүрэм 44*

Аль нэг төлөөлөгч төслийн санал буюу төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах саналын тодорхой хэсгээр тусдаа санал хураалт явуулах хүсэлт гаргаж болно. Ийнхүү тусгаарлах хүсэлтийг эсэргүүцсэн санал гарвал Ерөнхийлөгч хүсэлтийг дэмжиж болон эсэргүүцэж үг хэлэх зөвшөөрлийг нэг нэг төлөөлөгчид олгож, үг хэлсний дараа шууд санал хураалт явуулна. Ерөнхийлөгч үг хэлэх хугацаанд хязгаар тогтоож болно. Тусгаарлах хүсэлтийг хүлээн авч, төслийн тодорхой хэсгээр тусдаа санал хураалт явуулж баталсан тохиолдолд төслийг бүхэлд нь батлах эсэх санал хураалт явуулна. Төслийн санал буюу төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын үндсэн хэсгийг зөвшөөрөөгүй тохиолдолд саналыг бүхэлд нь зөвшөөрөөгүйд тооцно.

#### *Дүрэм 45*

1. Төсөлтэй холбоотой нэмэлт өөрчлөлт оруулах санал гарсан тохиолдолд нэмэлт өөрчлөлттэй холбоотой санал хураалтыг эхэлж явуулна. Төсөлтэй холбоотой хоёр буюу түүнээс дээш нэмэлт, өөрчлөлт оруулах санал гарсан тохиолдолд Ерөнхийлөгчийн үзсэнээр анхны төслийн утга агуулгаас хамгийн их ялгаатай саналаар эхэлж санал хураалт явуулж, улмаар дараагийн их ялгаатай саналаар санал хураалт явуулах замаар бүх саналыг нэг нэгээр нь санал хураалтад оруулна. Нэг саналыг хүлээн зөвшөөрөх нь өөр нэг саналыг үгүйсгэх нөхцөл байдлыг бий болгож байгаа тохиолдолд хоёр дахь саналаар санал хураалт явуулахгүй.
2. Нэг буюу түүнээс олон нэмэлт өөрчлөлт оруулах саналыг баталсан тохиолдолд төслийг бүхэлд нь батлах эсэх санал хураалт явуулна. Хэрэв нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг төслийг анх санал болгосон тал хүлээн зөвшөөрсөн бол саналыг анхны төслийн бүрэлдэхүүн хэсэгт тооцож, тусдаа санал хураалт явуулахгүй. Төслийн тодорхой хэсэгт нэмэлт оруулах, тодорхой хэсгийг хасах буюу өөрчлөн найруулах саналыг нэмэлт өөрчлөлт оруулах санал гэж тооцно.
3. Төслийн саналыг орлуулах хүсэлтийг тусдаа төслийн санал гэж тооцно.

#### *Дүрэм 46*

Нэг асуудлаар хоёр буюу түүнээс олон төслийн санал ирүүлсэн тохиолдолд Оролцогч талуудын Бага хурлаас өөрөөр шийдвэрлээгүй бол төслийн саналуудаар ирүүлсэн дарааллынх нь дагуу санал хураалт явуулна. Оролцогч талуудын Бага хурал төслийн нэг саналаар санал хураалт явуулсны дараа дараагийн төслийн санал дээр санал хураалт явуулах эсэхийг шийдвэрлэнэ.

#### *Дүрэм 47*

Төслийн санал буюу түүнтэй холбоотой хүсэлтээр санал хураалт явуулж эхлэхээс өмнө тухайн санал буюу хүсэлтийг оруулсан тал өөрийн санал, хүсэлтийг эгүүлэн татаж болно. Ийнхүү эгүүлэн татсан санал буюу хүсэлтийг аль нэг Оролцогч тал дахин хэлэлцүүлэхээр өргөн барьж болно.

#### *Дүрэм 48*

Төслийн саналыг баталсан буюу татгалзсан бол тухайн хуралдаанд оролцож, санал хураалтад оролцсон Оролцогч талуудын гуравны хоёроос доошгүй нь өөрөөр шийдвэрлэснээс бусад тохиолдолд санал, хүсэлтийг тухайн хуралдаанаар дахин авч хэлэлцэхгүй. Асуудлыг дахин авч хэлэлцэх хүсэлттэй холбоотой үг хэлэх зөвшөөрлийг санал гаргасан тал, хүсэлтийг дэмжсэн нэг дэмжээгүй хоёр төлөөлөгчид өгч, дараа нь шууд санал хураалт явуулна. Нэгэнт

баталсан төслийн саналтай холбоотой аливаа баримт бичгийн үг, үсгийн болон тоо, тооцооллын алдааг засахын тулд Оролцогч талуудын гуравны хоёроос доошгүй саналаар хэлэлцүүлгийг дахин нээх шаардлагагүй.

## **САНАЛ ХУРААЛТ**

### *Дүрэм 49*

1. Оролцогч тал тус бүр 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд саналын нэг эрхтэй байна.
2. Бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд өөрийн эрх мэдлийн хүрээний асуудлаар санал хураалтад оролцохдоо Конвенцийн Оролцогч тал болсон өөрийн гишүүн орны тоогоор саналын эрхтэй байна. Тус байгууллага нь түүний аль нэг гишүүн улс саналын эрхээ хэрэгжүүлж байгаа тохиолдолд санал хураалтад оролцох эрхээ хэрэгжүүлэхгүй, эсрэгээр мөн адил.

### *Дүрэм 50*

1. Төсөв, санхүүгийн асуудлаар Конвенцийн 23.4 дүгээр зүйлд заасан санхүүгийн дүрмийн дагуу зөвшилцөж шийдвэр гаргана.
2. Бусад асуудлаар Оролцогч талуудын Бага хурал зөвшилцөж, тохиролцоонд хүрэх замаар шийдвэр гаргахыг эрмэлзэнэ.
3. Өмнөх 2 дугаар хэсэгт заасан шийдвэртэй холбоотой зөвшилцөлд хүрэх бүх хүчин чармайлт амжилтгүй болж, тохиролцоонд хүрч чадаагүй нөхцөлд Оролцогч талуудын Бага хурал дараах байдлаар асуудлыг шийдвэрлэнэ. Үүнд:
  - a. Конвенц болон энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол материаллаг асуудлыг санал хураалтад оролцсон Оролцогч талуудын гуравны дөрвийн саналаар шийдвэрлэнэ;
  - b. Процессийн асуудлыг санал хураалтад оролцсон Оролцогч талуудын энгийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
4. Тухайн асуудал материаллаг, процессийн аль нь болохыг Ерөнхийлөгч шийднэ. Ерөнхийлөгчийн шийдвэрийг эсэргүүцсэн саналаар шууд санал хураалт явуулна. Санал хураалтад оролцсон Оролцогч талуудын энгийн олонх эсэргүүцсэн саналыг дэмжсэнээс бусад тохиолдолд Ерөнхийлөгчийн шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

### *Дүрэм 51*

1. Сонгуулиас бусад асуудлаар санал хураалтыг гар өргөх байдлаар явуулна. Аль нэг Оролцогч тал хүсэлт гаргасан бол Оролцогч талуудыг нэг нэгээр нь нэр цохон санал хураалт явуулна. Нэр цохон санал хураалт явуулахдаа Оролцогч талуудын нэрийг Англи үсгийн дарааллаар дуудна. Хамгийн түрүүнд санал өгөх Оролцогч талын нэрийг сугалаагаар тодруулна.
2. Санал хураалтад оролцсон Оролцогч талуудын энгийн олонхоор урьдчилж тийнхүү шийдвэрлэсэн бол Оролцогч талуудын Бага хурал төсөвтэй холбоотойгоос бусад асуудлаар нууц санал хураалт явуулж болно. Энэхүү дүрмийн дагуу нууц санал хураалт явуулах эсэхийг санаал хураалт явуулна. шийдвэрлэхдээ гар өргөж Оролцогч талуудын Бага хурал тодорхой асуудлаар нууц санал хураалт явуулах шийдвэр гаргасан бол үүнээс хойш тухайн асуудлаар өөр аргаар санал хураалт явуулах санал гаргаж, шийдвэрлэж болохгүй.

3. Оролцогч талуудын Бага хурал санал хураалтыг механик аргаар явуулж байгаа тохиолдолд нэр цохон санал хураалт явуулахдаа саналыг Оролцогч тал тус бүрээр бүртгэнэ, харин гар өргөж санал хураалт явуулсан бол нэгдсэн дүнгээр бүртгэнэ.
4. Нэр цохон санал хураалт явуулсан тохиолдолд Оролцогч тал тус бүрийн өгсөн саналыг хуралдааны тэмдэглэлд тусгана.

#### *Дүрэм 52*

1. Ерөнхийлөгч санал хураалт эхэлснийг зарласнаас хойш санал хураалттай холбоотой дэг сахиулахаас бусад асуудлаар нэг ч төлөөлөгч санал хураалтын явцыг тасалдуулахыг хориглоно.
2. Санал хураалтыг явуулж дуусгасны дараа Ерөнхийлөгч Оролцогч талуудад өгсөн саналтайгаа холбоотой товч тайлбар үг хэлэх зөвшөөрөл өгч болно. Төсөлд нэмэлт өөрчлөлт орсноос бусад тохиолдолд төслийг санаачилсан тал саналтай холбоотой тайлбар өгөхгүй. Ерөнхийлөгч тайлбар өгөх хугацаанд хязгаар тогтоож болно.

#### *Дүрэм 53*

Оролцогч талуудын Бага хурал тухайн нэр дэвшигч буюу нэр дэвшигчдийн жагсаалтыг санал хураахгүйгээр батлахыг санал нэгтгэйгээр шийдвэрлэснээс бусад тохиолдолд сонгуулийг нууц санал хураалтаар явуулна. Санал хураалт явуулахаар бол Ерөнхийлөгч төлөөлөгч нараас хоёр хүнийг санал тоологчоор томилж, саналыг тоолоход туслуулна.

#### *Дүрэм 54*

1. Зөвхөн нэг хүн эсхүл нэг Оролцогч талыг сонгох шаардлагатай бөгөөд эхний санал хураалтаар нэг ч нэр дэвшигч санал хураалтад оролцсон Оролцогч талуудын энгийн олонх саналыг авч чадаагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг дахин хаалттай санал хураалтад оруулна. Хоёр дахь санал хураалтаар нэр дэвшигчдийн санал тэнцвэл Ерөнхийлөгч сугалаагаар асуудлыг шийдвэрлэнэ.
2. Ижил нөхцөлтэй хоёр буюу түүнээс олон сонгуульт албан тушаалд нэг дор сонгууль явуулж байгаа тохиолдолд эхний санал хураалтаар хамгийн олон санал авсан бөгөөд санал хураалтад оролцсон Оролцогч талуудын энгийн олонх саналыг авч чадсан нэр дэвшигчдийг сонгоно.
3. Ийнхүү олонх санал авсан нэр дэвшигчдийн тоо сонгогдох ёстой хүн эсхүл Оролцогч талын тооноос бага байвал хоосон орон тоог нөхөх нэмэлт хаалттай санал хураалт явуулах ба ингэхдээ нөхөх шаардлагатай байгаа орон тоог хоёрт үржүүлснээс ихгүй тооны өмнөх санал хураалтаар хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийг дахин санал хураалтад оруулна. Гурав дахь санал хураалт амжилтгүй болсон тохиолдолд нээлттэй санал хураалт явуулж, шаардлага хангасан бусад хүн, Оролцогч талд санал өгч болно.
4. Ийнхүү нээлттэй санал хураалтыг гурван удаа явуулсан ч нэр дэвшигч олонх санал авч чадаагүй нөхцөлд дараагийн гурван удаагийн хураалтыг хаалттай байгуулах ба ингэхдээ нөхөх шаардлагатай байгаа орон тоог хоёрт үржүүлснээс ихгүй тооны гурав дахь удаагийн нээлттэй санал хураалтаар хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийг дахин санал хураалтад оруулна. Улмаар бүх сонгуульт орон тоог нөхөх хүртэл санал хураалтыг гурав гурваар нь нээлттэй, хаалттай хэлбэрээр ээлжлэн явуулна.

### *Дүрэм 55*

Түдгэлзсэнээс бусад тохиолдолд төлөөлөгч сонгуульд оролцохдоо нөхөх шаардлагатай сул орон тооны тоогоор санал өгнө. Нөхөх шаардлагатай сул орон тооноос цөөн эсхүл илүү нэр бичсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.

### *Дүрэм 56*

Хоёр буюу түүнээс олон нэр дэвшигч ижил тооны санал авсны улмаас орон тоог нөхөх боломжгүй бол эдгээр нэр дэвшигчдийг дахин санал хураалтад оруулж, хэнийг сонгохыг шийдвэрлэнэ. Шаардлагатай бол энэхүү ажиллагааг давтана.

## **ХЭЛ БА ТЭМДЭГЛЭЛ**

### *Дүрэм 57*

Оролцогч талуудын Бага хурлын албан ёсны болон хуралдааны хэл нь Араб, Хятад, Англи, Франц, Орос, Испани хэл байна.

### *Дүрэм 58*

1. Албан ёсны аль нэг хэлээр хэлсэн үгийг бусад албан ёсны хэл рүү хөрвүүлнэ.
2. Оролцогч тал нь албан ёсны аль нэг хэл рүү хөрвүүлэх асуудлыг шийдвэрлэсэн нөхцөлд тухайн Оролцогч талын төлөөлөгч албан ёсны бус хэлээр үг хэлж болно. Хэлсэн үгийг Оролцогч тал албан ёсны аль нэг хэл рүү хөрвүүлснээр албан ёсны бусад хэл рүү Нарийн бичгийн даргын газрын орчуулагч нар хөрвүүлнэ.

### *Дүрэм 59*

Оролцогч талуудын Бага хурлын албан ёсны бүх баримт бичгийг албан ёсны бүх хэл рүү орчуулна.

### *Дүрэм 60*

Оролцогч талуудын Бага хурлын нэгдсэн хуралдааны үгчилсэн тэмдэглэл, Оролцогч талуудын Бага хурал болон түүний туслах байгууллагуудын хуралдаан болгоны тайланг албан ёсны зургаан хэлээр гаргана. Тайланг Нарийн бичгийн даргын газрын дэмжлэгтэйгээр Илтгэгч бэлдэж, түүнд хуралдааны үйл ажиллагаа болон аливаа шийдвэр, тогтоолыг тусгаж, хуралдаан хаахаас өмнө танилцуулж, зарчмын хувьд зөвшөөрүүлнэ.

### *Дүрэм 61*

Оролцогч талуудын Бага хурал, боломжтой бол түүний туслах байгууллагуудын хуралдааны тэмдэглэлийг Нарийн бичгийн даргын газарт хадгална.

### *Дүрэм 62*

Дүрэм 60-д дурьдсан тайлангийн төслийг төлөөлөгч нарт аль болох богино хугацаанд хүргүүлж, төлөөлөгчид тайланг хүлээж авснаас хойш арван тав хоногийн дотор тайланд оруулахыг хүсч буй засваруудаа Нарийн бичгийн даргын газарт бичгээр хүргүүлнэ.

### *Дүрэм 63*

Нарийн бичгийн даргын газар нь олон нийтийн буюу нээлттэй хуралдаан, уулзалтыг хааснаас хойш аль болох богино хугацаанд бүх Оролцогч тал болон ажиглагч нарт тайланг хүргүүлнэ. Хаалттай уулзалтын тайланг зөвхөн оролцогчдод хүргүүлнэ.

### *Дүрэм 64*

Олон нийтийн болон нээлттэй бүх хуралдаан, уулзалтын тайлан, Оролцогч талуудын Бага хурлын үгчилсэн тэмдэглэлийг нийтэлнэ.

### *Дүрэм 65*

Нарийн бичгийн даргын газрын дарга нь хуралдаанд оролцож буй төлөөлөгчдөд зориулж нэгдсэн хуралдаан, хороо болон дэд хорооны олон нийтийн уулзалтын үйл ажиллагааны тоймыг өдөр тутмын хуралдааны Сэтгүүл хэлбэрээр албан ёсны бүх хэлээр хэвлэн нийтэлнэ.

## **АЖЛЫН ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

### *Дүрэм 66*

Энэхүү Ажлын дүрэмд Оролцогч талуудын Бага хурлаас зөвшилцсөний үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулж болно.

## **КОНВЕНЦИЙН ХҮЧИН ЧАДАЛ**

### *Дүрэм 67*

Энэхүү Дүрмийн аль нэг заалт Конвенцийн аль нэг заалттай зөрчилдсөн тохиолдолд Конвенцийг дагаж мөрдөнө.

-oOo-

ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийг цар тахлын даяаршлын хариу болгон боловсруулсан юм. Тамхины цар тахлыг худалдааны либералчлал, гадаадын шууд хөрөнгө оруулалт, тамхины дэлхий нийтийн маркетинг, зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа, тамхины хууль бус худалдаа зэрэг хил дамнасан нийлмэл хүчин зүйлс өдөөж байдаг. ДЭМБ-ын ТХСК нь бүх хүний эрүүл мэндийн байж болох хамгийн дээд түвшинд хүрэх эрхийг баталгаажуулсан, нотолгоонд тулгуурласан олон улсын гэрээ юм.

Конвенцийн Нарийн бичгийн даргын газар  
ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц  
Дэлхийн эрүүл мэндийн байгууллага  
Avenue Appia 20, 1211 Geneva 27, Switzerland  
Утас: +41 22 791 50 43  
Факс: +41 22 791 58 30  
И-мэйл: [fctcsecretariat@who.int](mailto:fctcsecretariat@who.int)  
Вэб хуудас: [www.fctc.who.int](http://www.fctc.who.int)  
ISBN 978-92-4-151214-5